

“Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 1 дүгээр зүйлийн 1.3, 1.8, 3 дугаар зүйлийн 3.25, 3.27, 4 дүгээр зүйлийн 4.2, 4.9 дэх хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулсугай.

1.1.Нөхцөл, шаардлагын 1.3 дахь хэсгийг “Энэхүү нөхцөл шаардлагыг Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөлтэй телевизийн үйлчилгээ эрхлэгч дагаж мөрдөнө.” гэж, 1.8 дахь хэсгийг “Энэхүү нөхцөл, шаардлагад тусгаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, тусгай зөвшөөрлийн гэрээгээр зохицуулна.” гэж, 3 дугаар зүйлийн 3.25 дахь хэсгийг “Үйл ажиллагаа явуулахад шаардлагатай, хөтөлбөрийн онцлогт тохирсон хүний нөөцийг бүрдүүлсэн, мэргэжлийн инженер техникийн ажилтантай байна.” гэж, 3.27 дахь хэсгийг “Үйлчилгээ эрхлэгч нь тусгай зөвшөөрөл шинээр авч, үйл ажиллагаа эхлүүлэхийн өмнө техникийн үйл ажиллагааг шалгаж жигдрүүлэх туршилтыг нэг сараас илүүгүй хугацаанд хийнэ.” гэж, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг “Энэхүү нөхцөл шаардлагын 4.1-д заасан журам, хэмжилт, шалгалтын дүнг Зохицуулах хорооноос шаардсан тохиолдолд ирүүлнэ.” гэж, 4.9 дэх хэсгийг “Дууны түвшинг хянах, тохируулах чиг үүргийг холбогдох ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусгай үүрэгжүүлсэн байна.” гэж тус тус өөрчлөн найруулсугай.

1.2.Нөхцөл, шаардлагын 1 дүгээр зүйлийн 1.4, 1.5, 1.6, 1.7 дахь хэсэг, 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1, 3.2, 3.3, 3.15, 3.26 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1 хэсэг 6.5.2 дахь заалтыг тус тус хүчингүй болгосугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

Гарын үсэг

“ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА”-Д НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТАЛААР ТАНИЛЦУУЛГА

Үндэслэл, тайлбар

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-д заасан чиг үүргийн дагуу “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ыг 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 02 тоот тогтоолоор батлан гаргаж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдөр 5060 дугаартайгаар бүртгэснээр хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн болно.

Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээр “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д тус хуульд нийцүүлэн Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 тоот тогтоолоор, орон нутгийн телевизүүд хөтөлбөрөө олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дамжуулан бусад аймаг, сумдад дахин дамжуулах боломжийг бий болгох зорилгоор 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 33 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулан баталж, Захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд холбогдох хөдөлгөөнийг тухай бүр хийлгэн, даган мөрдөж байна.

Энэ удаа “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д хууль тогтоомжийн дагуу дараах үндэслэлүүдийн хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахаар төслийг боловсруулаад байна. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын хүрээнд байгуулагдсан Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор батлан гаргасан 01 тоот дүгнэлтээр зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулж байгаа захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлээс хасахыг даалгажээ. Үүнтэй уялдуулан зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг агуулсан захиргааны хэм хэмжээний актуудыг хянаж, холбогдох заалтыг хүчингүй болгох арга хэмжээг авах,
- Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17-д “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно.” гэсний дагуу тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх нөхцөл буюу шаардагдах баримт бичгийг заасан заалтуудыг хүчингүй болгохоор,
- Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 “захиргааны хэм хэмжээний акт дараах шаардлагыг хангасан байна гэсэн хэсгийн 60.1.8. бусад хуулийн заалтыг давхардуулан заалгүйгээр шаардлагатай тохиолдолд эшлэл хийгдсэн байх” гэсний хүрээнд Өргөн нэвтрүүлгийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн заалттай давхацсан заалтуудыг хасахаар,
- Үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор онцын шаардлагагүй материал, мэдээ тайлан авахгүй байх, зарим шаардлагагүй зохицуулалтыг хүчингүй болгох зэрэг зорилгоор дараах нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулан

санал авахаар холбогдох төрийн байгууллага, телевизийн үйлчилгээ эрхлэгч болон олон нийтэд нээлттэйгээр байршуулж байна.

Хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах заалтууд

№	Нөхцөл, шаардлагын заалт	Өөрчлөлт оруулах санал	Үндэслэл, тайлбар
	Нэг. Нийтлэг үндэслэл		
1	1.3. Энэхүү нөхцөл шаардлагын хүрээнд телевизийн үйлчилгээ эрхлэгч (цаашид “үйлчилгээ эрхлэгч” гэх) гэдэгт Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, 6.1.5, 6.1.6-д заасан арилжааны телевизийн үйлчилгээ, өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ болон төлбөртэй телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд хамаарах бөгөөд Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд заасан дүрэм, журам, шаардлага, энэхүү нөхцөл, шаардлага болон телевизийн үйл ажиллагаанд хамаарах үндэсний стандартыг мөрдөж ажиллана.	Дараах байдлаар өөрчлөн найруулах: 1.3 Энэхүү нөхцөл шаардлагыг Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөлтэй телевизийн үйлчилгээ эрхлэгч дагаж мөрдөнө.	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, 6.1.5, 6.1.6 дахь заалтуудад “арилжааны радио, телевизийн үйлчилгээ, өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн үйлчилгээ, төлбөртэй радио, ТВ-ийн үйлчилгээ” гэж нэгэнт зөвшөөрлүүдийн төрлүүдийг тодорхойлсон нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд агуулгын хувьд нэгэнт тусгагдсан ойлголтыг давхардуулсан байгааг хасаж, заалтыг өөрчлөн найруулав.
2	1.4. Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоход Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5-д заасны дагуу сонгон шалгаруулна.	Хүчингүй болгох /хуулийн заалттай давхацсан агуулгатай/	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5-д “энэ хуулийн 6.1.3, 6.1.6-д зааснаас бусад төрлийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг нээлттэйгээр сонгон шалгаруулах” гэж сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн төрлийг заасан байдаг тул нөхцөл, шаардлагаас хасах.
3	1.5 Хөтөлбөрийн төрөлжсөн чиглэл, үйлчилгээ эрхлэх хүрээ, үйлчилгээний онцлогоос хамааран тавигдах нарийвчилсан шаардлагыг сонгон шалгаруулалтын баримт бичигт зааж болно.	Хүчингүй болгох /хуулийн заалттай давхацсан агуулгатай/	Сонгон шалгаруулалтын баримт бичигт Зөвшөөрлийн тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль зэрэг зөвхөн хууль тогтоомжид заасан шаардлагуудыг бичнэ.
4	1.6 Телевизийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалтад телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд оролцох бол ӨНТХ-ийн 7.4.1, 7.4.2, 7.4.3, 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 -т заасныг харгалзан үзнэ.	Хүчингүй болгох /хуулийн заалттай давхацсан агуулгатай/	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.1, 7.4.2, 7.4.3 дахь заалтууд, 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсгүүдэд тусгай зөвшөөрөл олгохдоо баримтлах зарчмыг хуульчилсан байх тул журамд давхардуулан тусгах шаардлагагүй.
5	1.7 Олон нийтийн телевизийн үйлчилгээнд тавигдах нөхцөл, шаардлагатай холбоотой харилцааг Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар зохицуулна.	Хүчингүй болгох /хуулийн заалттай давхацсан агуулгатай/	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “Олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар

			зохицуулна." гэсэн хуулийн заалттай давхацсан тул заалтыг хүчингүй болгох.
6	1.8. Энэхүү нөхцөл, шаардлагад тусгаагүй бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Радио давтамжийн тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм журам, нөхцөл шаардлагаар зохицуулна.	Дараах байдлаар өөрчлөн найруулах: 1.8. Энэхүү нөхцөл, шаардлагад тусгаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, тусгай зөвшөөрлийн гэрээгээр зохицуулна.	Нөхцөл, шаардлагад тусгаагүй бусад харилцааг зохицуулах нь зөвхөн нэр дурдсан эдгээр хуулиудаар хязгаарлагдахгүй бөгөөд Монгол Улсын холбогдох хуулиудаар зохицуулагдана. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хооронд байгуулдаг тусгай зөвшөөрлийн гэрээгээр хуулийн хүрээнд зохицуулах харилцааг тусгасан.
	Хоёр. Үйлчилгээ эрхлэх хүрээ		
7	2.6. Монгол Улсын нутаг дэвсгэрт болон энэхүү нөхцөл шаардлагын 2.4-т заасан хүрээнд үйлчилгээ эрхлэгч нь тусгай зөвшөөрөлд заасан байршилд үйл ажиллагаа явуулна.	Хүчингүй болгох /хуулийн заалттай давхацсан агуулгатай/	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 21.1-д "Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч нь тусгай зөвшөөрөлд заасан төрөл, үйлчилгээ эрхлэх хүрээ, байршилд үйл ажиллагаа явуулна." гэж заасантай давхацсан.
	Гурав. Телевизийн үйлчилгээ эрхлэх ерөнхий нөхцөл		
8	3.1 Телевизийн үйлчилгээ эрхлэхэд дараах нөхцөлийг бүрдүүлнэ:	Хүчингүй болгох	Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн "17.Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно." гэсэнд нийцүүлэв. Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгүүдэд агуулгын хувьд тусгагдсан.
9	3.1.1 Үйлчилгээ эрхлэх дунд хугацааны буюу 5 жилийн стратеги төлөвлөгөө боловсруулж, баталсан байх;		
10	3.1.2 Стратеги төлөвлөгөөнд хөтөлбөрийн бодлогыг тодорхойлж, салбарын хөгжилд хэрхэн хувь нэмэр оруулахыг тусгасан байх ба төлөвлөгөө нь тооцоо судалгаанд суурилсан, бодитой, хэрэгжихүйц байна;		
11	3.1.3 Шаардлагатай хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн, бизнес төлөвлөгөө гаргасан байх;		
12	3.1.4 Стратеги болон бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлсэн байх;		
13	3.1.5 Телевизийн хөтөлбөр бэлтгэж, нэвтрүүлэх, дамжуулахад шаардлагатай сүлжээ, студи, техник тоног төхөөрөмжийг тооцож, төлөвлөсөн байх;		
14	3.1.6 Гадаад, дотоодын студи, контент бүтээгчээс нэвтрүүлэг, контент авах бол зохиогчийн эрхийн төлбөр, гэрээний талаар тооцож, төлөвлөсөн байх;		

15	3.1.7 Ашиглах техник, тоног төхөөрөмж нь холбогдох стандарт, техникийн зохицуулалт болон аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан, итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын тохирлын гэрчилгээтэй байх;		
16	3.1.8 Студийн гаралт дахь дууны чанга дуугаралтын (loudness) түвшинг Европын өргөн нэвтрүүлгийн холбооноос баталсан EBU R128 зөвлөмжид заасан үзүүлэлтийн дагуу хянаж, тохируулах техник, программ хангамжийн боломжийг бүрдүүлсэн байх.		
17	3.2 Үйлчилгээ эрхлэгч нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон эрх, үүрэг хариуцлагаа бусдад шилжүүлэх, үндэслэн үйл ажиллагаа, эрх үүргийг өөрчилсөн аливаа хэлбэрийн гэрээ байгуулахгүй байна.	Хүчингүй болгох /хуулийн заалттай давхацсан агуулгатай/	Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 19 дэх заалт “Хуульд зааснаас бусад тохиолдолд энэ зүйлийн 18-д зааснаас бусад зөвшөөрлийг худалдах, бэлэглэх, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэхийг хориглоно.” гэсэн нь тусгай зөвшөөрлийг бусдад аливаа хэлбэрээр шилжүүлэхийг хориглосон тул хэм хэмжээний актад давхар утгаар зохицуулах шаардлагагүй.
18	3.3 Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн төрлийг өөрчлөхгүй.	Хүчингүй болгох	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн “21.1.Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч нь тусгай зөвшөөрөлд заасан төрөл, үйлчилгээ эрхлэх хүрээ, байршилд үйл ажиллагаа явуулна.” гэж заасан, мөн Зөвшөөрлийн тухай хуулиар хэрэв өөр төрлийн тусгай зөвшөөрөл авах бол дахин тусгай зөвшөөрөл хүсэж шинээр авах нь нэгэнт хуулиар тогтсон үндсэн зарчим тул нөхцөл, шаардлагад энэхүү хязгаарлалтыг заавал тусгах шаардлагагүй.
20	3.15 Үйлчилгээ эрхлэгч нь телевизийн эфирт нэвтрүүлэх хөтөлбөрт хяналт тавих, хариуцлага хүлээх чиг үүрэгтэй өөрийн редакцтай байх ба баримтлах бодлого, зарчим, ёс зүйг редакцын дүрмээр тодорхойлно. Редакцын бодлого, дүрэм нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд заасан зарчимд нийцсэн байна.	Хүчингүй болгох /хуулийн заалттай давхацсан агуулгатай/	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 дахь заалтад “радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч нь өөрийн редакцын бодлого, дүрэмтэй байх” гэж заасантай агуулгын хувьд давхцаж байна. Харин “...өөрийн нэвтрүүлгийн хөтөлбөрт хариуцлага хүлээнэ” гэх агуулга нь тусгай зөвшөөрлийн гэрээний агуулгад давхар тусгагдсан байх тул энэхүү заалтыг хасах.
21	3.25 Үйлчилгээ эрхлэгч нь мэргэжлийн инженер техникийн ажилтантай байна.	Дараах байдлаар өөрчлөн найруулах: 3.25 Үйл ажиллагаа явуулахад шаардлагатай, хөтөлбөрийн онцлогт тохирсон хүний нөөцийг	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 8 дугаар зүйл тусгай зөвшөөрөл хүсэгчид тавих ерөнхий шаардлагын “8.1.2 стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын, хүний нөөцийн, техник технологийн болон аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан байх” гэсэнд нийцүүлэв. Тусгай зөвшөөрөл хүсэгчид

		бүрдүүлсэн, мэргэжлийн инженер техникийн ажилтантай байна.	тавих шаардлага нь тусгай зөвшөөрөл авсны дараа мөн тавих шаардлага юм.
22	3.26 Үйлчилгээ эрхлэгчийн инженер, техникийн ажилтнууд нь телевизийн үйл ажиллагаанд баримтлах үндэсний стандартын сургалтад хамрагдсан байна.	Хүчингүй болгох	Үндэсний стандартын сургалт байхгүй байгаа, мөн энэхүү нөхцөл, шаардлагын 3.25-д үйлчилгээ эрхлэгч нь мэргэжлийн инженер, техникийн ажилтантай байхаар заасан байгаа тул энэхүү заалтыг хасах.
23	3.27 Үйлчилгээ эрхлэгч нь тусгай зөвшөөрөл шинээр авч, үйл ажиллагаа эхлүүлэхийн өмнө зөвхөн техникийн үйл ажиллагааг шалгах зорилгоор нэг сараас илүүгүй хугацаанд техникийн туршилт хийж болно. Техникийн туршилт хийхэд хөтөлбөр дамжуулахгүй.	Дараах байдлаар өөрчлөн найруулах: 3.27 Үйлчилгээ эрхлэгч нь тусгай зөвшөөрөл шинээр авч, үйл ажиллагаа эхлүүлэхийн өмнө техникийн үйл ажиллагааг шалгаж жигдрүүлэх туршилтыг нэг сараас илүүгүй хугацаанд хийнэ.	Тусгай зөвшөөрөл анх авсны дараа үйл ажиллагаа эхлүүлэхэд техникийн туршилт хийхдээ хөтөлбөр дамжуулах боломжийг олгосон.
Дөрөв. Телевизийн үйлчилгээний чанарт тавих шаардлага			
24	4.2 Энэхүү нөхцөл шаардлагын 4.1-д заасан журам, хэмжилт, шалгалтын дүнг Зохицуулах хорооноос шаардсаны дагуу тухай бүр болон хагас жил тутам статистик тайлангийн хүрээнд ирүүлнэ.	Дараах байдлаар өөрчлөн найруулах: 4.2 Энэхүү нөхцөл шаардлагын 4.1-д заасан журам, хэмжилт, шалгалтын дүнг Зохицуулах хорооноос шаардсан тохиолдолд ирүүлнэ.	Студи, техник төхөөрөмжийн болон дамжуулж буй гаралтын дуу, дүрсийн дохионы хэмжилтийн дүнг хагас жил тутам статистикийн тайлангаар авахаар заасан байсныг хасаж зөвхөн Зохицуулах хорооноос шаардсаны дагуу ирүүлэхээр өөрчлөлт оруулав. Энэ нь үйлчилгээ эрхлэгчид дарамт учруулахгүй байх, тайлан мэдээний тоог бууруулах, үйл ажиллагааг дэмжих зохицуулалт юм.
25	4.9 Дууны түвшинг хянах, тохируулах үүрэгтэй орон тооны ажилтантай байна.	Дараах байдлаар өөрчлөн найруулах: 4.9 Дууны түвшинг хянах, тохируулах чиг үүргийг холбогдох ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусгай үүрэгжүүлсэн байна.	Дууны түвшинг хянах, тохируулах үүрэгтэй орон тооны ажилтантай байх гэсэн хатуу шаардлагыг хасаж, байгууллага дотоод зохион байгуулалтаараа хариуцсан ажилтнаа томилох уян хатан зохицуулалтыг тусгав.
Зургаа. Телевизийн үйлчилгээ эрхлэх нэмэлт нөхцөл, шаардлага			

25	6.1 Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгч нь хөтөлбөрөө олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр заавал дамжуулна.	Хүчингүй болгох /хуулийн заалттай давхацсан агуулгатай/	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.21-д "өргөн нэвтрүүлгийн радио, телевиз" гэж олон талт хөтөлбөртэй, энэ хуулийн 6.1.2-т заасан үйлчилгээний сүлжээгээр заавал дамжих арилжааны радио, телевизийн үйлчилгээг" хэлнэ гэж заасантай агуулгын хувьд давхацсан гэж үзсэн.
26	6.5.2 Сэтгүүлч, сурвалжлагчийн ажлыг чиглүүлэх, бэлтгэсэн мэдээ, мэдээлэл нь редакцын бодлого, ёс зүйн хэм хэмжээ, холбогдох хууль, журам, Монгол хэлний хэм хэмжээ зэрэгт нийцэж байгаа эсэхийг хянах чиг үүрэгтэй орон тооны мэдээний редактортай байх.	Хүчингүй болгох /хуулийн заалттай давхацсан агуулгатай/	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн "31.3.2.радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч нь өөрийн редакцын бодлого, дүрэмтэй байх" гэж заасан, энэхүү нөхцөл, шаардлагын 3.19, 3.20-д заасан агуулгатай давхац байгаа тул заалтыг хүчингүй болгох.

**ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ТӨСӨЛ БЭЛТГЭХ
ЯВЦАД ХИЙСЭН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ**

/”Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д өөрчлөлт оруулах/

№	Аргачлал	Асуудал	Дэлгэрэнгүй тайлбар /судалгаа байгаа бол хавсаргах/
1	Акт гаргах үндэслэл, шаардлага, зорилтыг тодорхойлох	Хуулиар тусгайлан эрх олгогдсон байх	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтаар “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ыг Харилцаа холбооны зохицуулах хороонд батлах эрх олгогдсон.
2		Тухайн шийдвэрийг хэрэгжүүлснээр тавьсан зорилгод хүрч чадах эсэхийг тогтоох	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтын дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 02 тоот тогтоолын хавсралтаар баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 5060 дугаарт бүртгэгдсэн. Нөхцөл, шаардлагад Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээр тус хуульд нийцүүлэн Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 тоот тогтоолоор, орон нутгийн телевизүүд хөтөлбөрөө олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дамжуулан бусад аймаг, сумдад дахин дамжуулах боломжийг бий болгох зорилгоор 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 33 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулан баталж, Захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд холбогдох хөдөлгөөнийг хийлгэн, даган мөрдөж байна. Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын хүрээнд байгуулагдсан Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн өргөтгөсөн хуралдааны дүгнэлт, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэгт нийцүүлэн хуулийн заалттай давхардсан хэсэг, заалтыг хүчингүй болгох болон үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор онцын шаардлагагүй материал, мэдээ тайлан авахгүй байх, давтамжийг цөөрүүлэх зорилго тавьсан. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийг хийснээр дээр дурдсан зорилгод хүрнэ гэж үзэж байна.
3		Зорилт нь тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байх	“Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-д оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуулиудад нийцүүлж боловсруулсан. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 3-6 дугаар бүлэгт заасан Харилцаа холбооны зохицуулах хорооны чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгод нийцсэн болно.
4	Тухайн актын ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ	Актаар зохицуулах харилцааны хүрээ, хэмжээг тодорхой заах	“Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын зохицуулах харилцааны хүрээ нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, 6.1.5, 6.1.6 дахь заалтуудаар тодорхойлсон телевизийн үйлчилгээний төрөл буюу Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.2, 9.7, 9.14-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үйлчилнэ.

5		Бүтцийн хувьд гарчиг, тэмдэглэх хэсэг, тогтоох хэсэг, шаардлагатай бол урьд гаргасан шийдвэрийг хүчингүй болгох тухай хэсэг болон акт хүчин төгөлдөр болох хугацааг заах	Энэхүү тогтоол нь Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т “Захиргааны хэм хэмжээний актыг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ.” гэж заасныг үндэслэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөж эхэлнэ.
6		Бүтцийн хувьд хэдэн бүлэг, хэдэн зүйлтэй байхыг заах	Баримт бичиг нь бүтцийн хувьд 8 зүйл, 70 хэсэг, 19 заалттай.
7	Акт батлагдсаны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийг тодорхойлох		Баримт бичигт оруулах нэмэлт, өөрчлөлт батлагдсанаар телевизийн үйлчилгээ эрхлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь шууд хөндөгдөхгүй. Телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн одоогийн тусгай зөвшөөрөл, эрхлэх үйл ажиллагаанд өөрчлөлт орохгүй. Уг баримт бичигт оруулах өөрчлөлтийн төслийг Харилцаа холбооны зохицуулах хорооны www.crc.gov.mn цахим хуудсаар 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс 11 дүгээр сарын 27-ны өдрийг хүртэл 30 хоногийн хугацаатайгаар санал авахаар байршуулсан. Мөн тус Хорооноос нийт телевизийн үйлчилгээ эрхлэгчдэд болон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Монополын эсрэг газар, Монголын телевизүүдийн холбоо НЭЗХЭ, Арилжааны телевизүүдийн Дуун холбоо ТББ, Орон нутгийн телевизүүдийн Гал хөгжил холбоо ТББ-уудад санал авахаар хүргүүлэв. Телевиз, холбогдох байгууллага, холбоодын саналыг авч, тусган Хорооны Даргын зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, ээлжит Хорооны хуралдаанд танилцуулж батална.
8	Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх	Хүний эрх, эрх чөлөө ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Үгүй
9		Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарласан бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Үгүй
10		Жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Тийм
11		Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй
12		Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх	Үгүй
13		Зах зээлд шинээр орж ирж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл, хүндрэлийг бий болгох эсэх	Үгүй

14		Төрийн байгууллага болон аж ахуйн нэгж байгууллагад захиргааны шинж чанартай нэмэлт ачаалал бий болгож байгаа эсэх	Үгүй
15		Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсооход хүргэх эсэх	Үгүй
16		Эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд ямар нэгэн саад хориг тогтоох эсэх, хэрэв тийм бол тэр нь хуульд нийцсэн эсэх;	Үгүй
17		Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Үгүй
18		Хүнд суртал, авлига гарах нөхцөл, боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт байгаа эсэх, байгаа бол тэр нь хуульд нийцсэн эсэх;	Үгүй
19	Тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт гаргах эсэх	Эрх зүйн зохицуулалтын давхардал үүссэн эсэх	Үүсээгүй.
20	Актыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоог хийх	Шинээр төрийн байгууллага байгуулах эсэх	Үгүй
21		Төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийгдэх эсэх	Үгүй
22		Захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Үгүй
23		Тухайн шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдон улсын төсөв болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зардал үүсэх, эсхүл зардал бууруулах эсэх	Үгүй

Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газар

2025 он